

**БУЛГАН АЙМГИЙН 2024 ОНЫ 1 САРЫН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2024-02-07

Булган

2024 оны 1 сарын байдлаар нийт орлого ба тусламжийн дүн **6,5** тэрбум төгрөг буюу 131,1 хувийн, нийт зарлага **4,5** тэрбум төгрөг буюу 52,3 хувийн гүйцэтгэлтэй байна.

1. Төсвийн орлого

Нийт орлого ба тусламжийн дүн **5,5** тэрбум төгрөг буюу **131.1** хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт орлого ба тусламжийн дүн 2,1 тэрбум төгрөг буюу 48,0 хувь, урсгал орлого 1,9 тэрбум төгрөгөөр буюу 50,9 хувиар өссөн байна. Урсгал орлогын гүйцэтгэл **5,6** тэрбум төгрөг буюу **138,1** хувь байна.

(сая төг)

Орлогын нэр төрөл	Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	хэмнэлт/хэтрэлт (Тайлант үеийн)		хэмнэлт/хэтрэлт /Өмнөх оны мөн үетэй	
		жилээр	тайлант үе /өссөн дүнгээр/		зөрүү	Хувь, %	зөрүү	Хувь, %
1	2	3	4	5	(4-5)	(5:4)	(5-2)	(5:2)
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,424.9	79,315.2	4,995.9	6,548.7	(1,552.8)	131.1	2,123.8	148.0
Урсгал орлого	3,699.9	54,643.1	4,073.4	5,626.1	(1,552.8)	138.1	1,926.2	152.1
Татварын орлого	3,372.9	49,517.9	3,733.9	5,117.4	(1,383.5)	137.1	1,744.4	151.7
Татварын бус орлого	327.0	5,095.2	339.4	508.8	(169.3)	149.9	181.8	155.6
Хөрөнгийн орлого	27.2	30.0	-	-	-	#DIV/0!	(27.2)	-
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлсэн орлого	697.8	24,672.0	922.5	922.5	-	100.0	224.7	132.2
ОНХНСангаас шилжүүлсэн орлого	-	13,601.6	-	-	-	#DIV/0!	-	#DIV/0!
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	697.8	11,070.4	922.5	922.5	-	100.0	224.7	132.2

Нийт орлогын 14,1 хувийг тусламж санхүүжилтийн орлого, 78.1 хувийг татварын орлого, 7,8 хувийг татварын бус орлого эзэлж байна. Үүнээс ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 3,7 тэрбум төгрөг буюу татварын орлогын 71,8 хувийг бүрдүүлсэн байна.

Сумдын хувьд төсвийн нийт орлого ба тусламжийн дүн **21,0** тэрбум төгрөг буюу **99,8** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: татварын орлогыг сумаар авч үзвэл:

(сая төг)

д/д	Сумын нэр	2024 он төлөв.	2024 он 1 сар төлөв.	2024 он 1 сар гүйц.	зөрүү	хувь, %
1	Баян-Агт	571	26.7	22.4	4.3	83.9
2	Баяннуур	443.8	36	42.4	-6.4	117.8
3	Бугат	391.2	17.7	0	17.7	0.0
4	Булган	6574.8	396	468.7	-72.7	118.4
5	Бүрэгхангай	2251.5	101.5	106.2	-4.7	104.6
6	Гурванбулаг	501.8	20.5	38.2	-17.7	186.3
7	Дашинчилэн	411.6	23.9	26.2	-2.3	109.6
8	Могод	419.1	19.4	15	4.4	77.3
9	Орхон	799.4	30.2	29.7	0.5	98.3
10	Рашаант	1155.9	58.9	197.1	-138.2	334.6
11	Сайхан	510.5	19.3	47.1	-27.8	244.0
12	Сэлэнгэ	574.8	38	43.1	-5.1	113.4
13	Тэшиг	1007	43.8	63.2	-19.4	144.3

14	Хангал	3515.8	280.3	370.6	-90.3	132.2
15	Хишиг-Сндер	531.9	24.3	41.3	-17	170.0
16	Хутаг-Сндер	1348.1	86.9	53.7	33.2	61.8
17	Хялганат	561	46	53.2	-7.2	115.7
	СУМЫН ДҮН	21,569.2	1,269.4	1,618.1	-348.7	127.5
18	Аймгийн орлого	29,940.4	2,558.1	3,781.8	1223.7	147.8
	НИЙТ ОРЛОГО	51,509.6	3,827.5	5,399.9	-1572	141.1

Аймгийн дүнгээр авч үзвэл хувь хүний орлогын албан татвар, хадгаламжийн хүүгийн орлого, галт зэвсгийн албан татвар, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, ус рашааны нөөц ашигласны төлбөр биелжээ. Баяннуур, Булган, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Рашаант, Сайхан, Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хишиг-Өндөр сум, Хялганат тосгоны татварын орлогын төлөвлөгөө биелсэн байна.

- Аймгийн төсвийн орлогын хувьд цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлого, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, газрын төлбөрийн өмнөх онуудын дутууг аймгийн төсөвт төвлөрүүлсэн нь гүйцэтгэлд нөлөөлж байна. Засгийн газрын тогтоолоор усны хувь хэмжээ өөрчлөгдсөнөөс шалтгаалан үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого давж биелсэн байна.
- Сумдын хувьд нийт дүнгээр цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлого, хөрөнгийн орлого, үйл ажиллагааны орлого, шууд бус орлого, улсын тэмдэгтийн хураамж, үл хөдлөх хөрөнгийн албан татвар биелсэн байна.
- Монгол улсын Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх зээлийн хүрээнд Булган аймагт 3 төсөл арга хэмжээ хэрэгжиж, аймгийн төсвийн нөөц боломжтой уялдуулан 2022 оноос эхлэн зээлийн төлбөрийг төлж эхлээд байна. Дамжуулан зээлийн эцсийн хэрэглэгч болох Булган мээж ОНӨХХК нь Дулааны станц ашиглалтад орсноос шалтгаалан алдагдалтай ажиллаж, их хэмжээний дулааны өр төлбөртэй болсон, Тэшиг сумын Тэшиг ус ОНӨААТҮГ нь санхүүгийн хувьд дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрийг төлөх чадваргүй байгаагаас зээлийн авлага төсөвт төвлөрөх боломжгүй, төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө тасарч байна.

2. Төсвийн зарлага

Аймгийн төсвийн нийт зарлага **4,521.6** сая төгрөг буюу **52,3** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зардал **3,480.3** сая төгрөг буюу **47,2** хувь, орон нутаг дахь улсын төсвийн байгууллагын тогтмол зардал **1,041.3** сая төгрөг буюу **82.1** хувь байна.

Аймгийн Авто замын сангийн гүйцэтгэл 1,0 сая төгрөг буюу 50,0%, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 15.0 сая төгрөг буюу 5,0%, Орон нутгийн хөгжлийн сангаас гүйлгээ гараагүй байна. Аймгийн Байгаль хамгаалах сангийн гүйцэтгэл 90.5 сая төгрөг буюу 41,9% байна.

3. Төсвийн өглөг, авлага

Нийт өр **0,7** сая төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал 0,7 сая, өмнөх сартай харьцуулбал 17,2 сая төгрөгөөр тус тус буурсан байна.